



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нөмрөг сум Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2024/124/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Улиастай сум  
2025 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын  
дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа  
Утас: 99993365

Цахим хаяг: [Bat-Undraa@audit.gov.mn](mailto:Bat-Undraa@audit.gov.mn)

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: [Boldbaatarkh@audit.gov.mn](mailto:Boldbaatarkh@audit.gov.mn)

“Хаан соёмбо аудит” ХХК-ийн гэрээт аудитор  
Ж.Буянтогтох

Утас: 9904 2814

Цахим хаяг: [buyanaa99042824@gmail.com](mailto:buyanaa99042824@gmail.com)



## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	11
4. Аудитын тайлан.....	13
4.1 Ерөнхий зүйл .....	13
4.2 Материаллаг байдал .....	14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	16
5. Аудитын илрүүлэлт .....	16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	

---

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар





**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81090 Улиастай, Завхан аймаг  
Утас/Факс: 7046-36-12  
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2025.02.17 № 128  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

НӨМРӨГ СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Д.ХАЖИДМАА-Д

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нөмрөг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нөмрөг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Нөмрөг сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2024 онд 1,914,387.6 мянган төгрөгийн санхүүжилттэй ажиллаж, 152,412.8 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй, цахим ангийн болон интернет төхөөрөмжийн 29,948.0 мянган төгрөгийн өглөгтэй ажилласан байна.

Аудитын гол асуудал

Нөмрөг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар сургалтын төлбөрийг гэрээ болон анхан шатны баримтын бүрдэл дутуу, тайлангүй олгосон, цэвэр бохир усны зардлаас ариутгалын үйлчилгээ, шүүлтүүрийн үнэ шилжүүлж, зардлын эдийн засгийн ангилал гүйлгэн зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Нөмрөг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/04 дүгээр тогтоолоор сургуулийн 100 жилийн ойн хүрээнд эрдэм шинжилгээний хурлын зардал, ном бичих ажилд 25,000.0 мянган төгрөгийн төсөв баталсныг зарцуулсан байна.

D:/disk/Анбан бичиг/Дүгнэлт

812500193



Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

SORT_ID	Үзүүлэлт	ҮЛДЭГДЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	109,702,118.25	215,737,477.10
2	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	54,292,265.88	152,412,858.53
8	Банкинд байгаа бэлэн мөнгө	54,292,265.88	152,412,858.53
9	Төгрөг	54,292,265.88	152,412,858.53
10	Төрийн сангийн харилцах	54,292,265.88	152,412,858.53
14	Нэмэлт санхүүжилтийн харилцах	(0.00)	-
60	БАРАА МАТЕРИАЛ	55,409,852.37	63,324,618.57
61	Түүхий эд материал	16,138,300.00	17,423,250.00
62	Тусгай зориулалттай материал	16,138,300.00	17,423,250.00
66	Хангамжийн материал	39,271,552.37	45,901,368.57
67	Бичиг хэргийн материал	2,514,400.00	2,379,000.00
68	Аж ахуйн материал	19,253,882.37	14,454,403.57
69	Сэлбэг хэрэгсэл	277,000.00	-
72	Хүнсний материал	709,560.00	8,830,100.00
73	Бусад хангамжийн материал	16,516,710.00	20,237,865.00
86	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,763,375,812.52	1,772,238,450.69
106	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,763,375,812.52	1,772,238,450.69
108	Биет хөрөнгө	1,640,279,812.52	1,649,142,450.69
109	Барилга ,байгууламж	1,508,476,457.57	1,508,476,457.57
110	Хуримтлагдсан элэгдэл	(104,782,197.97)	(131,490,963.13)
113	Машин, тоног төхөөрөмж	216,418,394.33	276,585,136.33
114	Хуримтлагдсан элэгдэл	(118,416,175.29)	(139,214,949.88)
115	Тавилга, аж ахуйн эд хогшил	89,890,987.62	89,890,987.62
116	Хуримтлагдсан элэгдэл	(64,187,943.05)	(70,770,601.13)
121	Түүх соёлын дурсгалт зүйлс	10,119,316.67	10,119,316.67
122	Бусад үндсэн хөрөнгө	179,729,423.85	179,729,423.85
123	Хуримтлагдсан элэгдэл	(95,378,289.57)	(95,378,289.57)
125	Номын фонд	18,409,838.36	21,195,932.36



126	Биет бус хөрөнгө	123,096,000.00	123,096,000.00
127	Програм хангамж	2,400,000.00	2,400,000.00
128	Хасагдуулга	(1,410,000.00)	(1,410,000.00)
129	Бусад биет бус хөрөнгө	122,106,000.00	122,106,000.00
137	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,873,077,930.77	1,987,975,927.79
138	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	(0.00)	29,948,000.00
139	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	(0.00)	29,948,000.00
164	Өглөг	(0.00)	29,948,000.00
170	Бусад өглөг	(0.00)	29,948,000.00
171	Байгууллагад төлөх өглөг	(0.00)	29,948,000.00
214	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	1,873,077,930.77	1,958,027,927.79
215	Засгийн газрын хувь оролцоо	1,873,077,930.77	1,958,027,927.79
216	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	1,701,662,487.29	1,701,662,487.29
217	Өмч: -Төрийн өмч	1,701,662,487.29	1,701,662,487.29
223	Хуримтлагдсан үр дүн	(246,659,258.12)	(175,578,751.10)
224	Өмнөх үеийн үр дүн	(340,666,387.18)	(340,666,387.18)
225	Тайлант үеийн үр дүн	94,007,129.06	84,949,997.02
227	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	418,074,701.60	418,074,701.60
231	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	1,873,077,930.77	1,987,975,927.79

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

SORT_ID	ITEM_NAME	ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,366,004,235.06	1,950,503,184.00
76	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	73,096,935.06	63,372,084.00
77	Нийтлэг татварын бус орлого	73,096,935.06	63,372,084.00
81	Төсөвт байгууллагын өөрийн орлого	73,005,435.06	63,372,084.00
83	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	27,256,500.00
86	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	73,005,435.06	36,115,584.00
92	Бусад орлого	91,500.00	-
111	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,292,907,300.00	1,887,131,100.00
112	Улсын төвлөрсөн төсвөөс	1,111,499,800.00	1,677,566,600.00



113	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,111,499,800.00	1,677,566,600.00
129	Орон нутгийн төсвөөс санхүүжих	181,407,500.00	209,564,500.00
130	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	181,407,500.00	209,564,500.00
147	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	1,271,997,106.00	1,865,553,186.98
148	УРСГАЛ ЗАРДАЛ	1,271,997,106.00	1,865,553,186.98
149	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,237,239,886.00	1,803,937,610.04
150	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	807,880,659.71	1,184,661,593.21
151	Цалин	563,512,275.10	773,143,092.95
152	Нэмэгдэл цалин	208,772,531.76	348,046,000.26
154	Урамшуулал	35,595,852.85	63,472,500.00
157	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	95,805,375.21	144,190,943.78
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	65,540,828.49	98,854,130.94
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	7,457,049.27	11,788,012.51
160	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	6,732,550.22	5,870,906.26
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1,453,190.79	5,523,330.62
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	14,621,756.44	22,154,563.45
164	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	177,298,676.41	193,381,360.06
165	Гэрэл цахилгааны зардал	11,066,916.41	8,949,192.06
166	Түлш, халаалтын зардал	165,551,760.00	184,432,168.00
167	Цэвэр, бохир усны зардал	680,000.00	-
181	Нормативт зардал	59,054,902.00	58,451,750.00
183	Хоол	59,054,902.00	58,451,750.00
185	Эд хогшил, урсгал засварын зардал	3,162,000.00	2,000,200.00
189	Урсгал засвар	3,162,000.00	2,000,200.00
194	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	5,743,680.00	66,107,409.16
200	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	5,743,680.00	66,107,409.16
209	Бараа үйлчилгээний бусад зардал	88,294,592.67	155,144,353.83
210	Бараа үйлчилгээний бусад зардал	30,623,441.69	89,949,856.00
211	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	8,398,870.00	11,104,300.00
212	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	49,272,280.98	54,090,197.83
224	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,757,220.00	61,615,576.94



228	Бусад урсгал шилжүүлэг	34,757,220.00	51,094,837.00
232	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	34,757,220.00	33,821,845.00
236	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	-	17,272,992.00
242	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	10,520,739.94
245	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	10,520,739.94
268	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	94,007,129.06	84,949,997.02
288	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	94,007,129.06	84,949,997.02

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

SORT_ID	ITEM_NAME	ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,292,998,800.00	1,914,387,600.00
77	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	91,500.00	27,256,500.00
78	Нийтлэг татварын бус орлого	91,500.00	27,256,500.00
82	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	27,256,500.00
84	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	27,256,500.00
92	Бусад орлого	91,500.00	-
110	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,292,907,300.00	1,887,131,100.00
111	Улсын төвлөрсөн төсвөөс	1,111,499,800.00	1,677,566,600.00
112	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,111,499,800.00	1,677,566,600.00
129	Орон нутгийн төсвөөс санхүүжих	181,407,500.00	209,564,500.00
130	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	181,407,500.00	209,564,500.00
147	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	1,213,436,134.82	1,787,434,755.35
148	УРСГАЛ ЗАРДАЛ	1,213,436,134.82	1,787,434,755.35
149	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,170,121,534.82	1,722,098,023.41
150	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	800,570,734.92	1,165,025,436.99
151	Үндсэн цалин	560,692,224.24	733,994,748.37
152	Нэмэгдэл	203,481,530.38	364,917,397.42
154	Үр дүнгийн урамшуулал	36,396,980.30	66,113,291.20
157	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	103,115,300.00	163,827,100.00
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	70,118,200.00	99,333,400.00
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	8,250,000.00	29,345,800.00
160	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	6,599,800.00	7,358,500.00
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1,649,700.00	6,233,200.00



162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	16,497,600.00	21,556,200.00
164	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	177,407,500.00	195,043,760.06
165	Гэрэл цахилгааны зардал	11,175,740.00	8,950,592.06
166	Түлш, халаалтын зардал	165,551,760.00	184,432,168.00
167	Цэвэр, бохир усны зардал	680,000.00	1,661,000.00
181	Нормативт зардал	49,821,100.00	66,572,290.00
183	Хоол, хүнс	49,821,100.00	66,572,290.00
185	Эд хогшил, урсгал засварын зардал	4,000,000.00	4,000,000.00
189	Урсгал засвар	4,000,000.00	4,000,000.00
194	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,953,800.00	21,549,593.20
200	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,953,800.00	21,549,593.20
208	Бараа үйлчилгээний бусад зардал	29,253,099.90	106,079,843.16
209	Бараа үйлчилгээний бусад зардал	20,322,499.90	94,957,143.16
210	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	8,930,600.00	11,122,700.00
221	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43,314,600.00	65,336,731.94
225	Бусад урсгал шилжүүлэг	43,314,600.00	54,815,992.00
229	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	43,314,600.00	37,543,000.00
233	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	-	17,272,992.00
239	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	10,520,739.94
242	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	10,520,739.94
250	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	79,562,665.18	126,952,844.65
251	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
261	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	46,647,350.00	28,832,252.00
262	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	46,647,350.00	28,832,252.00
263	Дотоод эх үүсвэрээр Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	46,647,350.00	28,832,252.00
275	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(46,647,350.00)	(28,832,252.00)
279	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
303	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	32,915,315.18	98,120,592.65
304	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	21,376,950.70	54,292,265.88
305	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	54,292,265.88	152,412,858.53

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан



2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
0	ДАНС	511	51300	51210+51220	
2	2023 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	0	0	0	0
3	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
4	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	0	0
5	Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	0	0	0	0
6	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	0	0	0	0
7	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	0	0	0	0
8	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	0	0	0	0
9	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1701662487	418074701.6	-246659258.1	1873077931
10	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1701662487	418074701.6	-246659258.1	1873077931
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1701662487	418074701.6	-246659258.1	1873077931
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0	0	0	0
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0	0	0	0
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	0	0	0	0
16	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0	0	0	0
17	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	0	0	84949997.02	84949997.02
18	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1701662487	418074701.6	-161709261.1	1958027928

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

SORT ID	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
1	Монго, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	54,292,265.88	(54,292,265.88)	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,714,629,200.00	1,482,963,112.19	231,666,087.81	86.49
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1,714,629,200.00	1,482,963,112.19	231,666,087.81	86.49
4	Бараа, үйлчилгээний зардал	1,659,727,600.00	1,428,147,120.19	231,580,479.81	86.05
5	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,273,925,800.00	1,165,025,436.99	108,900,363.01	91.45
6	Үндсэн цалин	803,337,400.00	733,994,748.37	69,342,651.63	91.37
7	Нэмэгдэл	414,609,200.00	364,917,397.42	49,691,802.58	88.01
9	Урамшуулал	55,979,200.00	66,113,291.20	(10,134,091.20)	118.10
11	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	159,240,700.00	163,827,100.00	(4,586,400.00)	102.88
12	Тэтгэврийн даатгал	108,283,600.00	99,333,400.00	8,950,200.00	91.73
13	Тэтгэмжийн даатгал	12,739,300.00	29,345,800.00	(16,606,500.00)	230.36



14	ҮОМШӨ ний даатгал	6,369,600.00	7,358,500.00	(988,900.00)	115.53
15	Ажилгүйдлийн даатгал	6,369,600.00	6,233,200.00	136,400.00	97.86
16	Эрүүл мэндийн даатгал	25,478,600.00	21,556,200.00	3,922,400.00	84.61
30	Нормативт зардал	66,572,500.00	66,572,290.00	210.00	100.00
32	Хоол, хүнс	66,572,500.00	66,572,290.00	210.00	100.00
43	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	-	21,549,593.20	(21,549,593.20)	-
49	Мэдээллийн технологийн зардал	-	21,549,593.20	(21,549,593.20)	-
53	Бараа үйлчилгээний бусад зардал	159,988,600.00	11,172,700.00	148,815,900.00	6.98
54	Бараа үйлчилгээний бусад зардал	148,865,900.00	50,000.00	148,815,900.00	0.03
55	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,122,700.00	11,122,700.00	-	100.00
66	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	54,901,600.00	54,815,992.00	85,608.00	99.84
70	Бусад урсгал шилжүүлэг	54,901,600.00	54,815,992.00	85,608.00	99.84
74	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг	37,543,400.00	37,543,000.00	400.00	100.00
78	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	17,358,200.00	17,272,992.00	85,208.00	99.51
97	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	27,256,500.00	27,256,500.00	-	100.00
120	Нэмэлт санхүүжилтийн орлого	27,256,500.00	27,256,500.00	-	100.00
123	ЗГНХ, Засаг даргын нооц хөрөнгө түүнтэй адилтгах ангилалдаагүй нооц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухай төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	27,256,500.00	-	27,256,500.00	-
124	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	27,256,500.00	(27,256,500.00)	-
127	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	54,292,265.88	(54,292,265.88)	-
128	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	152,412,858.53	(152,412,858.53)	-

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

SORT_ID	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	(0.00)	0.00	-
100	ХӨТӨЛБӨР 71802	-	-	-	-
101	АРГА ХЭМЖЭЭ 80109	-	-	-	-
102	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	209,564,500.00	199,043,760.06	10,520,739.94	94.98
103	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	209,564,500.00	199,043,760.06	10,520,739.94	94.98
104	Бараа, үйлчилгээний зардал	209,564,500.00	199,043,760.06	10,520,739.94	94.98
117	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	205,564,500.00	195,043,760.06	10,520,739.94	94.88
118	Гэрэл цахилгаан	11,192,700.00	8,950,592.06	2,242,107.94	79.97



119	Түлш, халаалт	192,710,800.00	184,432,168.00	8,278,632.00	95.70
120	Цэвэр, бохир ус	1,661,000.00	1,661,000.00	-	100.00
134	Эд хогшил худалдан авах	4,000,000.00	4,000,000.00	-	100.00
138	Урсгал засвар	4,000,000.00	4,000,000.00	-	100.00
785	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	209,564,500.00	209,564,500.00	-	100.00
791	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	209,564,500.00	209,564,500.00	-	100.00
792	Орон нутгийн төсвөөс	209,564,500.00	209,564,500.00	-	100.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

##### Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэл:

Хүүхэд бүрийн сурч хөгжих, эрүүл зөв амьдрах дадал, үйлийг дэмжих, суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгаж, суралцах тэгш боломжийг бүрдүүлэн, хичээл сургалтын үйл ажиллагаанд бүх талын хамтын оролцоог дэмжих, багш ажилтны ёс зүй, өөрийн удирдлагатай суралцахуй, багшлахуйг эрхэмлэн хөгжүүлэх замаар сургалт, үйл ажиллагааны чанарт ахиц гаргахаар зорилго тавин ажиллаж байна

##### Ерөнхий боловсролын сургуулийн зорилго:

ХҮҮХДИЙН СУРАХ ҮЙЛИЙГ ДЭМЖИЖ СУРЛАГЫН ХОЦРОГДЛЫГ БАГАСГАН, ТЭДНИЙ ХӨГЖИЛ ТӨЛӨВШИЛ СУРЛАГЫН ЧАНАРТ АХИЦ ГАРГАН ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭХЭД ОРШИНО.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд мөрддөг хууль:

1. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
2. Төрийн албаны тухай хууль
3. Боловсролын тухай хууль
4. Төсвийн тухай хууль
5. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
6. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
7. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
8. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
9. Хөдөлмөрийн тухай хууль
10. Бага дунд боловсролын тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Дотоод хяналтын багийг байгуулж, төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Мөн Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд ЕБС-ын захирал, санхүүгийн албаны дарга, төсөв, төрийн сангийн мэргэжилтэн нар хяналтыг хийж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр



санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нөмрөг сумын ерөнхий боловсролын сургууль нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Нөмрөг сумын ерөнхий боловсролын сургууль нь 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 114,897.99 мянган төгрөгөөр буюу 0.6 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	0	0	0
Бараа материал	55,409.85	63,324.61	7,914.76
Үндсэн хөрөнгө	1,763,375.81	1,772,238.45	8,862.64
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,873,077.93</b>	<b>1,987,975.92</b>	<b>114,897.99</b>
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,873,077.93	1,958,027.9	84,949.97
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,873,077.93</b>	<b>1,987,975.92</b>	<b>114,897.99</b>

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

#### Тайланд онд:

Авлагын эхний болон эцсийн үлдэгдэлгүй байна.

Бараа материалын эхний үлдэгдэл 55,409.85 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 175,552.06 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 1,995 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, 169,632.3 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, эцсийн үлдэгдэл 63,324.61 мянган төгрөг болж, өмнөх оноос 7,914.76 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн хувьд төсвийн хөрөнгөөр 28,832.25 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, хөрөнгө оруулалтаар 34,120.58 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, жилийн эцэст 1,772,238.45 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Тайлант оны элэгдлийн зардалд 438,264.8 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 84,949.97 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй шууд холбоотой болно.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв



Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,292,998.8 мянган төгрөг, нийт зарлагыг 1,292,998.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Цалин, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл, Засаг даргын нөөц хөрөнгийг тодотголоор нэмж баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,240,919.3 мянган төгрөгийг төсвөөс төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,101,259.95 мянган төгрөг буюу 94.7 хувьтай байна. Энэ нь гэрэл цахилгаан, шуудан холбоо, хичээл үйлдвэрлэлийн дадлага, мэдээлэл сурталчилгаа зэрэг зардлыг 139,659.35 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

төгрөгөөр/		/мянган			
Хөтөлбөр арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>					
71802	Ерөнхий боловсрол				
80226	Байр ашиглалтын зардал	2,670.5	2,670.5	-	100%
81816	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	71,197.3	58,383.56	12,813.74	99.7%
81823	Боловсролын байгууллагын багш ажилтны мэргэжил дээшлүүлэх	8,011.5	3,000.0	5,011.5	0%
81827	Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр	24,578.2	19,685.89	4,892.31	100%
81834	Боловсролын стандарт	1,077,425.1	966,441.7	110,983.4	71.1%
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	53,036.7	48,821.8	4,214.9	75.8%
83603	Нэмэлт –дээд шатны төсвөөс хуваарилсан	4,000.0	2,256.5	1,743.5	
<b>НИЙТ</b>		<b>1,240,919.3</b>	<b>1,101,259.95</b>	<b>139,659.35</b>	<b>94.7%</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хөтөлбөр арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
----------------------	----------	------------	-----------	-------	---------



71802	Ерөнхий боловсрол				
80109	ТЗШ-ийн бга-уудын тогтмол зардал	209,564.5	199,043.76	10,520.74	94.9
	НИЙТ	209,564.5	199,043.76	10,520.74	94.9

Орон нутгын санхүүжилтээр 209,564.5 мянган төгрөгийн тогтмол зардал төвлөрүүлж, батлагдсан төсвийн дагуу 199,043.76 мянган төгрөгийг зарцуулж, 10,520.74 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

#### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

*/мянган төгрөг/*

№	Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга	Бараа ажил үйлчилгээний нэр	Төлөвлөлт	Гүйцэтгэл
1	Шууд гэрээ байгуулах	Хүүхдийн хоол	66,572.29	66,572.29
2	Шууд гэрээ байгуулах	Бараа үйлчилгээний бусад зардал	23,789.39	23,789.39
3	Шууд гэрээ байгуулах	Мэдээлэл технологийн зардал	21,549.59	21,549.59
4	Шууд гэрээ байгуулах	Түлш халаалтын зардал	184,432.16	184,432.16
5	Шууд гэрээ байгуулах	Гэрэл цахилгааны зардал	8,950.59	8,950.59
6	Шууд гэрээ байгуулах	Хичээл үйлдвэрлэлийн зардал	11,122.70	11,122.70
<b>ДҮН</b>			<b>316,416.72</b>	<b>316,416.72</b>

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Нөмрөг сумын Ерөнхий болосролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг "Хаан соёмбо аудит" ХХК-ийн гэрээт аудитор Ж.Буянтогтох гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Б.Дагвасүрэн анхан шатанд хянаж, чанарын хяналтыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсүвд, аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Нөмрөг сумын Ерөнхий болосролын сургууль нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 02 дугаа сарын 05-ны өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.



## **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг 1,271,997.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 12,719.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 10,175.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,865,533.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 18,655.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 14,924.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 31 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

## **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 5 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

## **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Завсрын аудитаар ороогүй байна.

### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 6,574.13 мянган төгрөгийн зөрчилд 5 заалт зөвлөмж, 425.13 мянган төгрөгийн зөрчилд акт өгөгдсөнийг хэрэгжүүлэн ажилласан байна.



Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	425.13	1	425.13	100%
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	5	6,149.0	5	6,149.0	100%
Нийт дүн	6	6,574.13	6	6,574.13	100%

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудалгүй байна.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 29,051.2 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 24,390.2 мянган төгрөгийн алдааг тайлангын явцад залруулж, 4661.0 мянган төгрөгийн 2 зөвлөмжийг өгөв.

**Залруулсан алдаа:** БЕГазраас олгосон ТВ, chrombook орлогод аваагүй, орон нутгын мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг төвлөрүүлэх зардалд бичээгүй зэрэг 24,390.2 мянган төгрөгийг санхүүгийн тайланд залруулав.

##### 5.1 Төлбөрийн акт тогтоогдоогүй

##### 5.2 Албан шаардлага: өгөгдөөгүй

##### 5.3 Зөвлөмж

- **Илэрүүлэлт-1:** Багшлахуйн Баясгалан төвд олгосон сургалтын төлбөр нь гэрээ анхан шатны баримт дутуу, тайлангүй олгосон Нягтлан Бодох Бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно" заалтыг зөрчиж байна.
- **Зөвлөмж :** Анхан шатны баримтын бүрдэл дутуу байхад гүйлгээ хийх, тайлан гаргахгүй байх
- **Илэрүүлэлт-2:** Цэвэр бохир усны зардлаас ариутгалын үйлчилгээ, шүүлтүүрийн үнэ шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах; Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар", -ыг тус тус зөрчсөн байна.
- **Зөвлөмж :** Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргаж, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар", -ыг мөрдөж ажиллах

Дээрх зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг түвшингөөс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруу-лаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
БЕГаараас олгосон ТВ, chrombook орлогод аваагүй, орон нутгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг төвлөрүүлэх зардалд бичээгүй	1	24,390.2	1	24,390.2			1	24,390.2				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>24,390.2</b>	<b>1</b>	<b>24,390.2</b>			<b>1</b>	<b>24,390.2</b>				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Багшлахуйн Баясгалан төвд олгосон сургалтын төлбөр нь гэрээ анхан шатны баримт дутуу, тайлангүй олгосон	1	3,000.0					1	3,000.0				
Цэвэр бохир усны зардлаас ариутгалын үйлчилгээ, шүүлтүүрийн үнэ шилжүүлсэн	1	1,661.0					1	1,661.0				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>4,661.0</b>					<b>2</b>	<b>4,661.0</b>				




АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

АХЛАХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР:

Ц.ОЮУНСУВД  
Х.БОЛДБААТАР  
Д.БАТ-УНДРАА



Огноо: 2025-02-24

БОЛОВСРУУЛСАН:

“ХААН СОЁМБО АУДИТ” ХХК-ИЙН  
ГЭРЭЭТ АУДИТОР Ж.БУЯНТОГТОХ

Огноо: 2025-02-24

